МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 12 сарын 24 өдөр | Дугаар А/576 | Мандалговь

"Шилдгийн шилдэг дуучин"-г шалгаруулах уралдаанд дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 /а/, 29.1.6 /г/, Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.8, 16.1.10, 16.1.12, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.3 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн 18 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Монгол Улсын хэмжээнд 2 дахь жилдээ хэрэгжиж буй "Үл тасрах аялгуу" төслийн хүрээнд "1960, 1970, 1980-иад оны дууг Хэн сайн дуулах вэ?" төрөл бүрийн мэргэжлийн хүмүүсийн дунд зохион байгуулсан улсын уралдааны тэргүүн байр эзэлсэн шагналтнуудын нэгдсэн тоглолтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсүгэй.

Хоёр. Уралдааны үйл ажиллагаанд 516000 (Таван зуун арван зургаан мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн ЗДТГ-ын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА О.БАТ – ЭРДЭНЭ

48801075